



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Цант орхон” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/08-НА-СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2023 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК

Утас: 77280808 Цахим хаяг: [nitsbalance@gmail.com](mailto:nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 “Цант Орхон” ААТҮГ-ын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт..	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

ААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨХБАҮХАТ хууль	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

“ЦАНТ ОРХОН” ААТҮГ-ЫН ДАРГА  
Д.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2023-03-15 № СЭА-2023/08-НА-СТА-ОНА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол “Цант Орхон” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн ажилтнуудад амралт сувиллын хөнгөлөлт олгосон, шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн, зардлыг судалгаа тооцоон дээр үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс батлагдсан зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.2, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд ажил, үйлчилгээний нийт орлогыг 778,607.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,089,499.2 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 39.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлыг 1,224,922.9 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,245,676.6 мянган төгрөгийн зардал гаргаж, төлөвлөгөөг 20,753.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн, 290,137.8 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийн дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын ариутгах татуургын сүлжээ, цэвэрлэх барилга байгууламж зэрэг хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг санхүүгийн тайлагналын зориулалтаар дахин үнэлүүлснээр барилга байгууламжийн өртөг 8,191,260.1 мянган төгрөгөөр буурсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	313,569,977.21	419,622,839.18
1.1.2	Дансны авлага	89,207,565.17	69,037,441.77
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		33,047.00
1.1.6	Бараа материал	55,144,936.73	64,090,973.88
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>457,922,479.11</b>	<b>552,784,301.83</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	23,475,237,682.52	15,050,908,790.38
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>23,475,237,682.52</b>	<b>15,050,908,790.38</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>23,933,160,161.63</b>	<b>15,603,693,092.21</b>
2.1.1.3	Татварын өр	5,147,403.04	3,099,726.63
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,147,403.04</b>	<b>3,099,726.63</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>5,147,403.04</b>	<b>3,099,726.63</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	1,917,096,129.00	1,937,114,135.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,765,404,928.04	14,574,144,861.64
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(754,488,298.45)	(910,665,631.06)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(240,998,266.55)	(156,177,332.61)
2.3.9	Өмнөх үеийн ашиг	(513,490,031.90)	(754,488,298.45)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>23,928,012,758.59</b>	<b>15,600,593,365.58</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>23,933,160,161.63</b>	<b>15,603,693,092.21</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>904,184,669.38</b>	<b>1,078,439,918.35</b>
2	Борлуулалтын өртөг	1,106,284,181.24	1,195,660,456.20
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>(202,099,511.86)</b>	<b>(117,220,537.85)</b>
4	Түрээсийн орлого	4,862,727.25	8,419,090.90
5	Бусад орлого	3,249,692.72	2,640,243.00
6	Ерөнхий ба удирдлагын зардал	26,859,266.75	46,487,910.47
7	Бусад зардал	3,723,188.18	3,528,218.19
8	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	(16,428,719.73)	
<b>9</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(240,998,266.55)</b>	<b>(156,177,332.61)</b>
10	Орлогын татварын зардал		
<b>11</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(240,998,266.55)</b>	<b>(156,177,332.61)</b>
12	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
<b>13</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(240,998,266.55)</b>	<b>(156,177,332.61)</b>



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021оны 12-р сарын 31	2022оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	943,408,911.12	1,210,572,128.02
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	943,408,911.12	1,210,572,128.02
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	929,473,714.40	1,199,081,965.02
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,138,204.00	890,420.00
	Бусад мөнгөн орлого	7,796,992.72	10,599,743.00
	Мөнгөн зарлагын дүн (-)	798,935,015.80	1,037,933,866.05
	Ажиллагчдад төлсөн	341,715,936.63	452,831,100.45
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	90,674,943.96	107,478,755.90
1.2	Бараа материал худалдан авахад төлсөн	141,963,030.00	219,337,794.00
	Ашиглалтын зардалд төлсөн	65,405,694.45	73,022,646.83
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	60,225,720.00	52,417,750.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	89,171,505.76	112,861,083.87
	Даатгалын төлбөрт төлсөн	2,037,675.00	2,391,300.00
	Бусад мөнгөн зарлага	7,740,510.00	17,593,435.00
	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	144,473,895.32	172,638,261.97
	Мөнгөн зарлагын дүн (-)	26,661,300.00	56,885,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	26,661,300.00	56,885,000.00
<b>1.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	(26,661,300.00)	(56,885,000.00)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(3,470,000.00)	(9,700,400.00)
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	3,470,000.00	9,700,400.00
	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	114,342,595.32	106,052,861.97
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	199,227,381.89	313,569,977.21
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	313,569,977.21	419,622,839.18

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>Орлогын нийт дүн</b>	<b>778,607,716.00</b>	<b>1,089,499,252.25</b>	- <b>310,891,536.25</b>	<b>140.0</b>
<b>Цэвэр борлуулалтын дүн</b>	<b>768,607,716.00</b>	<b>1,078,439,918.35</b>	- <b>309,832,202.35</b>	<b>140.00</b>
Цэвэр усны борлуулалт	16,790,400.00	14,597,730.95	2,192,669.05	87.00
Бохир усны борлуулалт	640,417,200.00	887,791,600.86	- 247,374,400.86	138.60
Халуун усны үйлчилгээний орлого	39,487,500.00	69,065,090.90	- 29,577,590.90	174.90
Зочид буудал үйлчилгээний орлого	71,912,616.00	106,985,495.64	- 35,072,879.64	148.70
Бусад орлого	10,000,000.00	11,059,333.90	- 1,059,333.90	110.50
<b>Нийт зардлын дүн</b>				
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,179,833,710.0	1,195,660,456.20	- 15,826,746.20	102.40
Ерөнхий удирдлагын зардал	31,922,264.00	46,487,910.47	-14,565,646.47	145.6
<b>Цэвэр ашиг алдагдал</b>	<b>(437,649,258.00)</b>	<b>(156,177,332.61)</b>	<b>(281,471,925.39)</b>	<b>35.60</b>
Үйл ажиллагааны бус зардал	4,500,000.00	3,528,218.19	971,781.81	78.4

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Цант Орхон” ААТҮГ нь “Мандал суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, айл өрхөөс гарсан бохир усыг татан авч Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, технологийн дагуу цэвэршүүлэн байгальд ээлтэйгээр, нийлүүлж, орон нутагтаа бизнесийн бусад үйл ажлаараа бүрэн тогтворжсон чадварлаг хамт олон болно” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

“Цант Орхон” ААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг цэвэр усаар хангах.
- Аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйл ажиллагаа явуулах.
- Зочид буудал, үсчин гоо сайхан, дулаан гражаар үйлчилж гадаад дотоод худалдаа эрхлэх.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### 3.2 “Цант Орхон” ААТҮГ-ын гадаад, дотоод орчин

“Цант Орхон” ААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Цант Орхон” ХХК нэртэйгээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Цант Орхон” ААТҮГ болгон өөрчилж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийг татан буулгасан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, 19 дүгээр зүйл: “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийг хэрэгжүүлэх, тендерийн гүйцэтгэлийн баталгаа гаргахад шаардлагатай зээлийн эрх олгох, компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт, гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд “Цант Орхон” ААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

“Цант Орхон” ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,329,467.1 мянган төгрөгөөр буюу 34.8 хувиар буурсан байна.

Энэ нь тайлант онд ариутгах татуургын сүлжээ, цэвэрлэх байгууламж зэрэг барилга байгууламжийн бодит үнэ цэнийг санхүүгийн тайлагналын зориулалтаар дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотой байна.

Амгын  
Төрийн  
Авгаа  
Материал  
Үндсэн

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	313,569.9	419,622.8	106,052.9
Авлага	89,207.6	69,037.4	(20,170.2)
Бараа материал	55,144.9	64,090.9	8,946.0
Үндсэн хөрөнгө	23,475,237.6	15,050,908.7	8,424,328.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>23,933,160.1</b>	<b>15,603,693.0</b>	<b>(8,329,467.1)</b>
Өр төлбөр	5,147.4	3,099.7	(2,047.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,928,012.7	15,600,593.3	(8,327,419.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>23,933,160.1</b>	<b>15,603,693.0</b>	<b>(8,329,467.1)</b>

Касс дахь бэлэн мөнгө 3,987.2 мянган төгрөг, харилцах дансанд 415,635.5 мянган төгрөг, нийт 419,622.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 20,170.2 мянган төгрөг буюу 22.6 хувиар буурсан хэдий ч сумын онцгой комисс ковидын үед тусгаарлах байраар ашиглаж байсан байрны түрээсийн төлбөр 46,700.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь авлагын үлдэгдэлтэй тайлагнагдахад нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 8,946.0 мянган төгрөгөөр буюу 16.2 хувиар өссөн нь сэлбэг хэрэгсэл, түлээ, нүүрсний нөөцтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 8,424,328.9 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 15,600,593.3 мянган төгрөг болж, 8,327,419.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Цант Орхон” ААТҮГ тайлант оны зорилтот түвшин, орлого, зарлага болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажилласан байна.

Тайлант онд нийт орлогыг 778,607.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,224,922.9 мянган төгрөгөөр, алдагдлыг 446,315.2 мянган төгрөг байхаар тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,089,499.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, баталсан төлөвлөгөөг 40.0 хувиар давуулан биелүүлэн 156,177.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант оны нийт алдагдал 156,177.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 190,137.8 мянган төгрөг буюу 65.0 хувиар буурсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,245,676.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 20,753.7 мянган төгрөг буюу 2.0 хувиар хэтэрсэн нь үйл ажиллагааны цар хүрээ ихсэж, орлогын төлөвлөгөө давж биелэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд ААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн аудитор Ц.Сувдаа гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ш.Ичинхорлоо, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цант Орхон” ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,106,284.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,062.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 19 төрлийн 179 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 2 удаа

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/634 дүгээр албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хэрэгжүүлэн алдагдалгүй ашигтай ажиллах бүхий л бололцоог ханган ажиллах, 2021 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн өглөг, авлагыг бууруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

Тайлант онд “Цант орхон” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон болон төлөвлөгдөөгүй зардал гаргасан, зарим нэр төрлийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчил гаргасан байна. Тухайлбал, сар бүр шагналт цалин нэрээр нийт 87,430.5 мянган төгрөгийг хавтгайруулан олгож, жилийн цалингийн санг 29,380.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, ажиллагсдын сувиллын хөнгөлөлтөд 1,389.3 мянган төгрөг, төлөвлөгөөнд

тусгагдаагүй харуул хамгаалалтын зардалд 2,590.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.2 дахь "ээлжийн амралтаараа дотоодын **амралт, сувиллын газарт**, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал", 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, **шагнал, урамшуулал, дэмжлэг олгох**" " гэж заасантай нийцэхгүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Цант орхон” ААТҮГ-ын 2022 оны завсрын аудитаар худалдан авах ажиллагаа болон Шилэн дансны нэгдсэн цахим системтэй холбоотой 2 эрсдэлийг илрүүлэн, зөвлөж өгч ажилласан болно.

Хүснэгт 2. Завсрын аудитын үр дүн, хэрэгжилт

Үзүүлэлт	Завсрын аудитын илрүүлэлт		Биелэлт		Зөрүү	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	хувь
Зөвлөмж	2	95,257.7	2	89,190.4	6,067.3	6.6
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>95,257.7</b>	<b>2</b>	<b>89,190.4</b>	<b>6,067.3</b>	<b>6.6</b>

Завсрын аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлт 93.4 хувийн биелэлттэй байгаа ба Шилэн дансны нэгдсэн цахим системтэй холбоотой 1 асуудал бүрэн биелээгүй, давтагдсан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 103,592.9 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 2,344.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоон, 1 албан шаардлага өгснөөс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,344.0	2	2,344.0	100.0
Албан шаардлага	1	-		-	
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>2,344.0</b>	<b>2</b>	<b>2,344.0</b>	<b>66.7</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Цант Орхон” ААТҮГ-ын ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллын талаар байгууллагын дотоод журамд заасан тодорхой бус заалтын дагуу сар бүр ажлын үр дүн, байгууллагын ашиг орлогыг тооцолгүй, нийт ажиллагсдад нэг хэмжээгээр хавтгайруулан олгож буй асуудлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайлант онд худалдан авсан 21,671.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсан алдааг илрүүлж, зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **303,837.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,389.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 244,233.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 58,214.5 мянган төгрөгийн зөрлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант хугацаанд байгууллагын ажиллагсдын амралт сувиллын хөнгөлөлтөд нийт 1,389.3 мянган төгрөгийг тооцож олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.2 -д “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж зөрчиж олгосон хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан 72,292.3 мянган төгрөгийн нүүрс, 47,658.1 мянган төгрөгийн шатахуун, 21,215.0 мянган төгрөгийн модны үртсийн худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 20,0 сая төгрөг” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Төлөвлөсөн орлогыг 310,891.5 мянган төгрөгөөр буюу 39.9 хувиар давуулан биелүүлсэнтэй холбогдож гарах зардлыг, өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дагалдаж гарах зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцож,

төлөвлөн батлуулаагүйгээс аймгийн Засаг даргын баталсан 2022 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан түлш шатахууны зардлыг 26,257.8 мянган төгрөгөөр, тоног төхөөрөмж, их засварын зардлыг 3,212.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 47,007.3 мянган төгрөгөөр зэрэг нийт 76,477.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, төлөвлөгдөөгүй 2,590.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын зардал гаргасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3 дахь “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар **батлуулан биелэлтийг хангах**” гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан “Цант Орхон ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3.Үйлдвэрийн газрын ажилтнуудын үндсэн болон нэмэгдэл цалин хөлсийг үндэслэлтэй тогтоож төлөвлөөгүйгээс ажлын үр дүн, байгууллагын үр ашгийг харгалзалгүйгээр ажилтнуудад сар бүр тодорхой бус шагнал олгосноос баталсан цалингийн зардлыг нийт 26,590.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх “*Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож,.....эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*”, 15.1.3 дахь “*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*” Байгууллагын дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.3. дахь “*байгууллага нь дараах зарчмыг цалин хөлсний бодлогод баримтална*”. 9.3.1 дэх “*байгууллагын ашиг, орлоготой уялдаатай байх*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудын үндсэн болон нэмэгдэл цалинг үндэслэлтэй тогтоож, батлуулах, хууль зөрчсөн шагнал олгохгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 5.3.Зөвлөмж

#### 1.Авлагын насжилт, барагдуулалттай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт: Харилцагч 3 байгууллагатай холбоотой олон жил дамнасан 51,355.5 мянган төгрөгийн авлагын тооцоог хянаагүй, барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах*”....., Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Олон жил болсон насжилт өндөртэй авлагын тооцоог хянах, дүн шинжилгээ хийх, барагдуулах арга хэмжээ авах, найдваргүй тохиолдолд холбогдох байгууллагуудад хандаж, данс бүртгэлээс хасах.

## 2. Үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан **21,671.4** мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хасалтын дүнг аймгийн Орон нутгийн өмчийн газрын олгосон зөвшөөрлийн дүнгээс **791.7** мянган төгрөгөөр дутуу буюу **9,324.9** мянган төгрөгөөр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 411 дүгээр албан бичигт “2022 оны 69 тоот албан бичгийн хавсралтад дурдсан 10,116.6 мянган төгрөгөөр балансад бүртгэж авахыг зөвшөөрөв” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг анхан шатны баримт, холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн үнэн зөв бүртгэж байх.

## 3. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримт

3.1. Тайлант онд 6,067.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4317143398  
 МҮОА00865 9056436

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд 4 мэдээллийг хугацаа хоцроосон	4	0.0			4	0.0		
Дүн	4	0.0			4	0.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								